



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2024/14/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn
Дундговь аймаг
2024 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох
Утас: 70592439
Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал
Утас: 70592225
Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ихбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: ikhbayard@audit.gov.mn

Аудитор: Ж.Угтахбаяр
Утас: 70593113
Цахим хаяг: Ugtakhbayarj@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	4
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	6
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	6
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	6
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	6
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	6
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	6
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	7
4. Аудитын тайлан	9
4.1 Ерөнхий зүйл	9
4.2 Материаллаг байдал	9
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	9
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	9
4.4.1 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	10
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	10
5. Аудитын илрүүлэлт.....	10
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан

1. Аудитын санал дүгнэлт



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайншинган сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

ДУНДГОВЬ АЙМГИЙН АДААЦАГ
СУМЫН ЗАСАГ ДАРГА Ч.УРАНЧИМЭГ
ТАНАА

2024-03-25 № 116
танил _____ ны № _____

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-т заасны дагуу Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад тайлант оны эхнээс орон нутагт ажиллаж байгаа төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгож эхэлсэн, Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр 2023 оны 07 сарын сарын 01-ээр төрийн албаны үндсэн цалинг нэмсэнтэй холбоотой цалингийн зардал өмнөх оноос 1.6 дахин өссөн, ахмадын сангийн үлдэгдлийг тухайн төсвийн байгууллагын хөтөлбөр арга хэмжээ болгон тайлагнадаг болсон. Санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллагын чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй бөгөөд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй.

Аудитын гол асуудал

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн Мал хамгаалах санд өмнөх аудитаар өгсөн 5,286.4 мянган төгрөгийн авлага барагдуулах албан шаардлагын үлдэгдлийг барагдуулаагүй, хэрэгжилтийг хангаагүй зөрчил нь тайлант үеийн өндөр үнэлэгдсэн эрсдэлтэй асуудал байлаа.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний

олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилт, 34 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний үнэлгээгээр 86.2 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Р.МӨНХТОГТОХ

2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	853,360.6	955,469.1
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	468,191.8	502,471.5
33	АВЛАГА	225,007.2	252,912.2
35	БАРАА МАТЕРИАЛ	160,161.5	200,085.4
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,477,437.6	1,614,624.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,477,437.6	1,614,624.8
39200	Биет хөрөнгө	1,462,179.6	1,593,556.0
39300	Биет бус хөрөнгө	15,258.0	21,068.7
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,330,798.2	2,570,093.9
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,150.0	14,925.0
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,150.0	14,925.0
41300	Өглөг	5,150.0	14,925.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,325,648.2	2,555,168.9
51	Засгийн газрын хувь оролцоо	2,325,648.2	2,555,168.9
51100	Засгийн газрын оруулсан капитал	608,503.9	608,503.9
51200	Хуримтлагдсан үр дүн	1,298,210.8	1,527,731.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	418,933.4	418,933.4
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,330,798.2	2,570,093.9

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,226,772.9	1,613,672.1
11	ТАТВАРЫН ОРЛОГО	240,263.9	391,602.6
110	Орлогын албан татвар	145,020.0	175,847.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	145,020.0	175,847.1
113	Хөрөнгийн албан татвар	73,970.4	68,268.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	21,273.4	147,486.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	234,573.3	229,783.7
120	Нийтлэг татварын бус орлого	234,573.3	229,783.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	751,935.7	992,285.9
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,120,726.0	1,186,907.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,120,726.0	1,186,907.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	816,752.0	945,477.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	228,443.6	363,676.4
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	27,833.9	44,535.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,849.6	19,261.2
2104	Хангамж, бараа материалын зардал	144,331.5	67,904.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,985.8	32,550.6
2107	Томилолт, зочны зардал	7,691.6	17,683.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,853.8	22,571.1
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	294,762.3	377,294.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	303,974.1	241,430.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	106,046.9	426,764.9
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,722,833.0	191,382.6
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	-2,616,786.1	235,382.3

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,171,200.3	5,171,200.3
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-228,766.0	-228,766.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,942,434.3	4,942,434.3

9	Тайлант үеийн үр дүн	-2,616,786.1	-2,616,786.1
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,325,648.2	2,325,648.2
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,325,648.2	2,325,648.2
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-5,861.5	-5,861.5
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,319,786.6	2,319,786.6
19	Тайлант үеийн үр дүн	235,382.3	235,382.3
20	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	2,555,168.9	2,555,168.9

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,186,528.4	1,574,155.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	240,263.9	391,602.6
110	Орлогын албан татвар	145,020.0	175,847.1
1100	Хувь хүний орлогын албан татвар	145,020.0	175,847.1
113	Хөрөнгийн албан татвар	73,970.4	68,268.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	21,273.4	147,486.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	13,584.4	20,701.1
1181	Газрын төлбөр	7,689.0	16,914.7
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	0.0	109,871.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	200,534.1	197,053.7
120	Нийтлэг татварын бус орлого	200,534.1	197,053.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	745,730.4	985,499.0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	872,263.1	968,924.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	872,263.1	968,924.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	794,605.9	939,075.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	281,900.2	364,761.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,428.3	44,582.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	186,484.4	19,261.2
2104	Хангамж, бараа материалын зардал	38,998.1	48,103.4
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	65,495.8	37,835.6
2107	Томилолт, зочны зардал	7,691.6	17,683.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,853.8	227,366.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	150,753.8	179,482.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	77,657.2	29,848.6
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	314,265.3	605,231.1
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	177,279.0	443,151.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	177,279.0	443,151.4
2200	Дотоод эх үүсвэрээр	177,279.0	443,151.4
2260	Гадаад эх үүсвэрээр	0.0	0.0
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-177,279.0	-443,151.4
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-72,000.0	-127,800.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	72,000.0	127,800.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	64,986.2	34,279.7
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	403,205.6	468,191.8
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	468,191.8	502,471.5

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг дарга нь төрийн үйлчилгээний үйл ажиллагаа явуулдаг, Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Тухайн байгууллага эрхэм зорилгоо “Төр иргэний оролцоог ил тод нээлттэй болгож иргэд олон нийтийн санал санаачилгад тулгуурлан төрийн бодлогыг шударгаар хэрэгжүүлнэ” гэж тодорхойлжээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тус байгууллага нь дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтангүй, дотоод аудитыг ТЕЗ-ийн харьяа Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дугаар тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт орсон байна. Төсөв захирагч нарын ахмадын сангийн тайланг үндсэн тайланд нэгтгэж тайлагнах тухай чиглэлийг аймгийн СТСХ-ээс албан бичгээр ирүүлсэн байна. Уг чиглэлийн дагуу ахмадын сангийн тайланг үндсэн тайланд нэгтгэн тайлагнажээ.

Тайлант хугацаанд Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

3.4.1 Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 239,295.7 мянган төгрөгөөр буюу 10.3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт №1.	/мянган төгрөг/			
	Тайлангийн үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
	Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн		853,360.6	955,469.1	102,108.5
Мөнгөн хөрөнгө		468,191.8	502,471.5	34,279.7
Авлага		225,007.2	252,912.2	27,905.0
Бараа материал		160,161.5	200,085.4	39,923.9
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		1,477,437.6	1,614,624.8	137,187.2

Үндсэн хөрөнгө	1,477,437.6	1,614,624.8	137,187.2
Нийт хөрөнгийн дүн	2,330,798.2	2,570,093.9	239,295.7
Нийт өр төлбөр	5,150.0	14,925.0	9,775.0
Богино хугацаат өр төлбөр	5,150.0	14,925.0	9,775.0
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,325,648.2	2,555,168.9	229,520.7
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,330,798.2	2,570,093.9	239,295.7

Эх сурвалж: Санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 34,279.7 мянган төгрөгөөр өссөн нь орон нутгийн ерөнхий орлогын дансны үлдэгдэлтэй холбоотой байна.

Авлагын дансны үлдэгдэл 27,905.0 мянган төгрөгөөр өссөн нь Хоршоо хөгжүүлэх сангаас зээл олголт хийгдэж зээлийн үлдэгдэл 211,226.1 мянган төгрөг болсон нь нийт авлагын 83.5 хувийг эзэлж байгаа нь нөлөөлсөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 39,923.9 мянган төгрөгөөр өссөн нь сумын Засаг даргын Тамгын газрын бараа материал өмнөх оноос 35,595.2 мянган төгрөгөөр өссөнтэй холбоотой байна. Энэ нь аж ахуйн материал дээр сумын ОНХС-аар хийгдсэн байгууламжийн зураг төслүүдийг бүртгэсэнтэй холбоотой байна. Мөн мал хамгаалах сангийн өвс, тэжээлийн үлдэгдэл өссөн нь нөлөөлсөн байна.

Тайлант онд сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгийн дансанд 137,322.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн нь нийт балансын дүн өсөхөд нөлөөлсөн байна. Энэ нь аймгийн болон сумын ОНХС-аар хийгдсэн худаг засвар, хогийн машин, гамшгийн тоног төхөөрөмж зэрэг бусад хандив тусламжаар ирсэн үндсэн хөрөнгүүдтэй холбоотой байна.

Цэвэр хөрөнгийн дансны үлдэгдэл 2,555,168.9 мянган төгрөг болж, 229,520.7 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

3.4.2 Орлого бүрдүүлэлт

Дундговь аймгийн Адаацаг сумын ИТХ-ын 2023 оны орон нутгийн төсөв батлах тухай 18 дугаар тогтоолоор Адаацаг сум тайлант онд 248,730.0 мянган төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсаныг 2023 оны 06 сарын 30-ны өдрийн 09 тогтоолоор өөрчлөлт оруулан 285,618.0 мянган төгрөг болгон тодотгож баталсан байна. Гүйцэтгэлээр нийт 424,390.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 148.6 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

(мянган төгрөг)

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого				
Цалин түүнтэй адилтгах орлого	136,188.0	167,956.2	31,768.2	123.3
Хувь хүний орлогын албан татвар	24,000.0	7,890.9	(16,109.1)	32.9
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	3,600.0	4,570.6	970.6	127.0
Бууны албан татвар	1,230.0	1,230.0	-	100.0
Улсын тэмдэгтийн хураамж	2,000.0	7,601.0	5,601.0	380.1
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	4,000.0	3,300.0	(700.0)	82.5
Газрын төлбөр	12,000.0	16,914.7	4,914.7	141.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	9,600.0	9,800.1	200.1	102.1
Малын тоо толгойн албан татвар	60,000.0	62,468.0	2,468.0	104.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	-	109,871.0	109,871.0	
Дүн	252,618.0	391,602.5	138,984.5	155.0
Татварын бус орлого				
Хадгаламжийн хүүгийн орлого	21,000.0	22,668.2	1,668.2	107.9
Торгуулийн орлого	12,000.0	10,120.0	(1,880.0)	84.3
Дүн	33,000.0	32,788.2	(211.8)	99.3
Нийт дүн	285,618.0	424,390.7	138,772.7	148.6

Эх сурвалж: Адаацаг сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дараах орлогууд материаллаг дүнгээр давж биелсэн байна. Үүнд:

- Цалин түүнтэй адилтгах орлогын албан татварын орлого 31,768.2 мянган төгрөгөөр давсан нь 2023 оны эхнээс орон нутгийн нэмэгдэл олгож эхэлсэн мөн хагас жилээр төрийн албан хаагчдын цалинг нэмэгдэсэнтэй холбоотой байна.
- Үл хөдлөх эд хөрөнгийн орлогын албан татварын орлого 970.6 мянган төгрөгөөр давсан нь суманд шинээр үл хөдлөх хөрөнгүүд баригдсантай холбоотой байна.

- Газрын төлбөр 4,914.7 мянган төгрөгөөр давсан нь суманд шинээр барилга баригдан, үйл ажиллагаа эрхлэх ААНБ-ын газрын тоо нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Малын тоо толгойн албан татвар 2,468.0 мянган төгрөгөөр давсан нь өмнөх жилийн дутуу татвар орж ирсэнтэй холбоотой.
- Улсын тэмдэгтийн хураамж 5,601.0 мянган төгрөгөөр давсан нь дэлгүүрүүдийн тусгай зөвшөөрлийг сунгасан байна.
- Хадгаламжийн хүүгийн орлого 1,668.2 мянган төгрөгөөр давсан нь иргэдийн хадгаламж нэмэгдэж, хадгаламжийн хүүг тооцож олгогдсонтой холбоотой байна.
- Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн төлөвлөгөө батлагдаагүй боловч Шонхор шувууны гэрээ байгуулан 109,871.0 мянган төгрөг оруулж ирсэн нь нийт орлогын төлөвлөгөө давж биелэх гол нөлөө үзүүлсэн байна.

Дараах нэр төрлийн орлого материаллаг дүнгээр тасарсан байна. Үүнд:

- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр 700.0 мянган төгрөгөөр тасарсан нь хууль, эрх зүйн орчин бүрдээгүйтэй холбоотой байна.
- Торгуулийн орлого 1,880.0 мянган төгрөгөөр тасарсан нь суманд гарсан зөрчлийн тоо буурсантай холбоотой байна.
- Хувь хүний орлогын албан татвар 16,109.1 мянган төгрөгөөр тасарсан нь ноос ноолуурын урамшуулал орж ирээгүйтэй холбоотой.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Адаацаг сумын ИТХ-ын 2022 оны 18 дугаар тогтоолоор сумын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,529,126.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,529,126.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, баталсан байна.

Адаацаг сумын ИТХ-ын 2023 оны 09 дугаар тогтоолоор батлагдсан төсөвт 1 удаа өөрчлөлт хийж, зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг тус бүр 223,148.1 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн, 1,752,274.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Тус онд төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэн, орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт нэмэгдсэнтэй холбоотойгоор санхүүжилтийг нэмэгдүүлэн баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд сумын Засаг даргын хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 1,752,274.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,020,652.7 мянган төгрөгийг урсгал зардалд, 592,621.7 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 139,000.0 мянган төгрөгийг эргэж төлөгдөх зээлд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 332,703.1 мянган төгрөгийг улсын төсвөөс 934,721.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 484,850.3 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 332,703.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 876,871.6 мянган төгрөг, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 154,837.7 мянган төгрөг нийт 1,364,412.4 мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлого 72,739.8 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 12,739.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлж, туслах үйл ажиллагааны орлого 82,097.9 мянган төгрөгийг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 10,097.9 мянган төгрөгөөр давсан, нийт төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 22,837.7 мянган төгрөгөөр давсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,447,754.8 мянган төгрөг буюу 82.6 хувьтай байгаа нь бараа үйлчилгээний бусад зардалд 923,817.8 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 396,137.0 мянган төгрөг, эргэж төлөгдөх зээлд 127,800.0 төгрөгийг зарцуулснаас шалтгаалсан байна.

Орон нутгийн санхүүжилтээс дутуу зарцуулсан 59,897.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд хандив тусламжаар 15,000.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 27,131.1 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 41,161.7 мянган төгрөг, нийт 83,292.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс: Хангамж бараа материалын зардалд 6,525.2 мянган төгрөг, эд хогшил, урсгал засварын зардалд 19,980.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 17,748.3 мянган төгрөг, томилолтын зардалд 3,760.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 25,440.0 мянган төгрөг, бараа, ажил үйлчилгээний зардалд нийт 73,453.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 9,839.2 мянган төгрөгийг төсвийн ерөнхийлөн захирагчийн орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” заасны дагуу Дундговь аймгийн Адаацаг сумын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Д.Должинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дүгээр сарын 04-ний өдрийн 01/52 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн тайлангаас үр дүнгийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үр дүнгийн нийт зардлын 1,186,907.2 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 17,803.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 13,352.7 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын санхүүгийн тайланг түүвэрлэн шалгахад Адаацаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвөөс сумын ИТХ-ын албан хаагчийг гадаадад туршлага судлах арга хэмжээнд хамруулж төсвөөс байр, хоол, унааны зардал 980.0 мянган төгрөг олгосон зөрчил илэрснийг давтан гаргахгүй байх хугацаатай албан шаардлага хүргүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 4 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг дарга нь 2023 онд нийт 153 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд тусгайлсан аудит хийгдээгүй болно.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна. Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга нь өөртөө захирамж гарган, шагнал урамшууллыг цалин хөлсний зардлаас тооцож 636.0 мянган төгрөг олгосныг төлбөрийн акт тогтоосон мөн сумын Орон нутгийн хөгжлийн сангаас хөрөнгийг магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулаагүй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулахаар 155,271.1 мянган төгрөгийг баталж санхүүжүүлсэн зөрчлүүд илэрсэн нь бусад хууль тогтоомжийн холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Дундговь аймгийн Адаацаг суманд 2023 онд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг даргын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд алдаа зөрчил илрээгүй. Харин нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудын төсвийн шууд захирагч нарт нийт 374,159.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 148,824.6 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулж, 1,670.9 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 223,663.7 мянган төгрөгийн 8 зөрчлийг арилгах албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмж хүргүүлсэн байна. Адаацаг сумын Мал хамгаалах сангийн 5,286.4 мянган төгрөгийн авлага барагдуулах албан шаардлага бүрэн хэрэгжээгүй тул хууль, журмын дагуу хариуцлага тооцуулах саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхээр болсон.

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	1,670.9	1	1,670.9			100
Албан шаардлага	8	223,663.7	7	215,070.3	1	8,593.4	96.1
Зөвлөмж	1		1				100
Нийт	10	225,334.6	9	216,741.2	1	8,593.4	99.2

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас татварын орлого бүрдүүлэлтийг шалгах горимыг дараагийн аудитаар хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

5. Аудитын илрүүлэлт

5.1 Сумын нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын Засаг даргын 2023 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 16,809.1 мянган төгрөгийн зөрчил¹ илэрч, 16,809.1 мянган төгрөгийн 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг харуулав. Үүнд:

1. Татварын орлогын бүрдүүлэлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын орон нутгийн татварын 12 нэр төрлийн орлогыг төвлөрүүлэхээс 3 нэр төрлийн 16,809.1 мянган төгрөгийн татварын орлогыг дутуу төвлөрүүлсэн байна. Энэ нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59.1.19-д /нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах/, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т /Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ/, 41.2.1-т /Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх/ гэсэн заалтыг тус тус зөрчсөн.

Өгсөн зөвлөмж: Татварын болон татварын бус орлогыг төлөвлөхдөө тайлант оны онцлог, эдийн засгийн нөхцөл байдлын өөрчлөлт, өмнөх оны гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, орлогын нэр төрлийг бүрэн төвлөрүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2024 оны 08 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5.2 Сумын нэгтгэсэн тайланд нэгтгэгдсэн төсвийн шүүд захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 4 тусгай сангийн нийт 6 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 1 байгууллагад дүгнэлт гаргаж, 1 байгууллага, 4 сан түүвэрт хамрагдсан байна.

Аудитад хамрагдсан Засаг даргын Тамгын газрын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл:

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	Засаг даргын Тамгын газар	1	1			1			
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1		1					
3	Мал хамгаалах сан	1		1					
4	Хоршоо хөгжүүлэх сан	1		1					
5	Орон нутгийн хөгжлийн	1		1					
6	Байгаль хамгаалах сан	1		1					
	НИЙТ	6	1	5		1			

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 198,940.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 27,079.4 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж, 1,190.7 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 170,670.5 мянган төгрөгийн 4 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн байна.

Аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийн 86.4 хувийг залруулагдаагүй, 13.6 хувийг залруулсан алдаа эзэлж байна.

Нийт 171,861.2 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчлийн 90.7 хувь буюу 155,907.1 мянган төгрөг нь нийцлийн аудитын асуудал, үлдсэн 9.3 хувь нь 15,954.1 мянган төгрөг нь санхүүгийн тайлангийн

аудитын зөрчил илэрчээ. Мөн Сумын Засаг даргын нэгтгэсэн тайлангаар илэрсэн 16,809.1 мянган төгрөгийн зөрчил нь нийцлийн аудитын асуудал байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн залруулахдаа боломжгүй, аудитын дүгнэлтэд нөлөөлөх 15,954.1 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон материаллаг түвшингээс 1,849.5 мянган төгрөгөөр буюу 11.6 хувиар бага байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.